



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/22

Улаанбаатар хот

### Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 3.2, 3.7, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны A/222 дугаар тушаал, Байгууллагын Архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 2.8, 2.9, 2.10, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.10 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Комиссын дарга:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Архивын ажилтан Хотын хөгжлийн стандартын хэлтсийн Хотын тээвэр логистикийн стандарт хариуцсан мэргэжилтэн Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн барилгын техникийн хяналтын улсын байцаагч Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч Байгаль орчны стандартын хэлтсийн хөрс, усны чанарын стандарт хариуцсан мэргэжилтэн Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн худалдаа, үйлчилгээний байгууллагын стандарт хариуцсан мэргэжилтэн


Нарийн бичгийн дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн бичиг хэргийн эрхлэгч

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг комиссын дарга (Э.Даваахатан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2022 оны A/13 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ



1150500107